

# АВАРГА ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү дүрмээр “Аварга” Дээд сургуульд суралцаж буй оюутны үүргийг баталгаажуулах, ёс зүйн хэм хэмжээг тогтоох, оюутнуудын гаргасан зөрчилд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын тогтолцоог бий болгоход энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2 Сургууль нь аливаа хүчирхийлэл, сүрдүүлгээс ангид, хууль журмыг ёсчлон биелүүлдэг, ардчилал, хүнийн эрхийг хүндэтгэн дээдэлдэг, оюутны суралцах таатай орчныг бүрдүүлсэн байна.

## Хоёр. Оюутны үүрэг

- 2.1 “Аварга” дээд сургуулийн оюутан нь Монгол улсын хууль тогтоомж, сургуулийн дүрэм, журмын заалт, сургалтын гэрээгээр хүлээсэн үүрэг, ёс зүйн энэхүү дүрмийг чанд сахина.
- 2.2 Сургуулийнхаа эрхэм зорилгыг дээдлэн хүндэтгэн, шинжлэх ухаанд шамдан суралцаж, эх орныхоо хөгжил дэвшилд өөрийн хувь нэмэр оруулах эрмэлзэлтэй шилдэг оюутан суралцагч байна.
- 2.3 Эрдэмтэн багш, ажилтан хамт олноо хүндэтгэн, нийгэм хамт олны үйлсэд өөрийгөө зориулна.
- 2.4 Сургуулийнхаа материаллаг бааз анги танхим дотуур байрны эд хөрөнгийг ариг гамтай ашиглана.
- 2.5 Хамт суралцаж буй бусад оюутнуудад ямар нэгэн дарамт шахалт саад хийхгүй нөхөрсөг хандан тусалж дэмжин хамтарна.
- 2.6 Сургууль дээр гарсан ёс зүйн зөрчлийг шаардлагатай байгууллагад мэдээлэнэ.

## Гурав. Ёс зүйн зөрчилд хамрагдах үйлдэл

- 3.1 Ёс зүйн зөрчил гэдэг ойлголтонд ёс зүйн үндсэн зарчмууд болон нийгмийн зан суртахууны түгээмэл хэм хэмжээнд харшилсан үйлдлийг хамруулан авч үзнэ. Үүнд:
  - 3.1.1 “Аварга” дээд сургуулийн эрхэм зорилго, нэр хүндийг гутаах, үл хүндэтгэх, сургуулийн захиргааны шийдвэрийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийх,
  - 3.1.2 Багш ажиллагсад оюутны биед халдах, үл хүндэтгэх, дайрч доромжлох, нэр төрийг нь сэвтүүлэх оролдлого хийх,
  - 3.1.3 Сургуулийн нутаг дэвсгэрт хар тамхи, архидан согтууруулах ундаа биедээ авч явсан буюу хэрэглэх,
  - 3.1.4 Сургалтын төлөвлөгөө, хичээл, дадлагын үйл ажиллагаанд саад учруулах,
  - 3.1.5 Сургуулийн байр, эзэмшилд нэвтрэн орох түлхүүр, лацыг зөвшөөрөлгүйгээр ашиглах, бусдад дамжуулах,
  - 3.1.6 Сургуулийн бичиг баримт, мэдээ материалыг гэмтээсэн, устгасан, хуурамчаар үйлдэх болон хэрэглэх,
  - 3.1.7 Багш, ажилтан болон эрх бүхий бусад хүмүүст хандан өөртөө ашигтай шийдвэр гаргуулахаар авилга, хээл хахууль өгөх буюу өгөхийг завдах,

- 3.1.8 Ёс зүйн зөрчил гаргасан этгээдийг мэдсэн атлаа түүнийг нь нуун дарагдуулах, өмөөрч хаацайлах,
- 3.1.9 Нийгмийн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан аливаа үйлдэл хийх,

#### **Дөрөв. Ёс зүйн зөрчил гаргасан оюутанд хүлээлгэх хариуцлага**

- 4.1 Ёс зүйн зөрчил гаргасан оюутанд зөрчлийн хэр хэмжээ, нөхцөл байдлыг харгалзан “Аварга” дээд сургуулийн ёс зүйн зөвлөл, сургуулийн захиргаанаас доорх хариуцлагыг хүлээлгэнэ.
  - 4.1.1 Амаар буюу бичгээр анхааруулга, сануулга өгч уучлал гуйлгах,
  - 4.1.2 Учруулсан хохирлыг төлүүлэх,
  - 4.1.3 Тус сургуулийн оюутан байх эрхийг хасах,
  - 4.1.4 Тодорхой нөхцөлтэйгээр үргэлжлүүлэн суралцуулах.
- 4.2 Сануулга өгч уучлал хүсүүлэх, хариуцлагыг ёс зүйн хөнгөн зөрчил гаргасан этгээдэд ногдуулах ба хичээлийн нэг жилийн хугацаанд оюутанд нэгээс илүү ногдуулахгүй.
- 4.3 “Аварга” дээд сургуулийн оюутан байх эрхийг хасах хариуцлагыг ёс зөрчил удаа дараа гаргасан буюу давтан ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд ёс зүйн хувьд сургуульд тэнцэхгүй хэмээн үзэж уг хариуцлагыг хүлээлгэнэ.
- 4.4 Сургуулиас хасагдах шийтгэл хүлээсэн этгээдэд сургалтын төлбөрийг нь буцаан олгохгүй бөгөөд энэ дүрэмд ёс зүйн зөрчил гэж заасан үйлдлүүдийг мэдээгүй байсан нь хариуцлага хүлээлгэхгүй байх үндэслэл болохгүй.

#### **Тав. Ёс зүйн зөвлөл**

- 5.1 “Аварга” дээд сургууль нь дэргэдээ оюутны ёс зүйн зөвлөлтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хамт, олон оюутны байгууллагын саналыг үндэслэн захирлын тушаалаар батална.
- 5.2 Оюутны ёс зүйн зөвлөл нь дарга, гишүүдтэй байх ба “Аварга” дээд сургуулийн Оюутны холбооны дарга, Сургалтын албаны дарга, Сургуулийн захирал, багш нарын төлөллөөс тус тус бүрдэнэ.
- 5.3 Оюутны ёс зүйн зөвлөл нь “Аварга” дээд сургуульд суралцагч оюутнуудын ёс зүйн зөрчлийг магадлан судалж, дүгнэлт гарган, сургуулиас хасуулахаас бусад тохиолдолд шийдвэр гаргах, сургуулиас хасах саналтай бол сургуулийн Захиргааны зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлэх, ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээ авах, ийм арга хэмжээ авахыг сургуулийн үүрэг бүхий албан тушаалтанд өгөх, энэхүү дүрмийг оюутнуудад таниулах, сахин биелүүлэх арга хэмжээг авах эрх үүрэгтэй.
- 5.4 Ёс зүйн зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа ээлжит хурал хийх бөгөөд уг хурлаараа сургуулийн хэмжээнд ёс зүйн асуудлуудыг шийдвэрлэн хэлэлцэнэ. Шаардлагатай тохиолдолд ёс зүйн зөвлөлийн санаачлагаар ээлжит бус хурлыг зарлаж болно.
- 5.5 Тус журмын 4.3-т заасан шийтгэл ноогдуулах асуудлыг захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар баталгаажуулна.

**Зургаа. Дүрэм хүчин төгөлдөр болох, нэмэлт өөрчлөлт оруулах**

- 6.1 Энэхүү дүрэм нь “Аварга” дээд сургуулийн Захирал гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Дүрэмд нэмэлт өөрчлөлт саналыг захирал, оюутны холбоо ёс зүйн зөвлөлөөс гаргах эрхтэй бөгөөд ёс зүйн зөвлөл уг асуудлыг шийдвэрлэнэ.

\* \* \*